

АЗИЙН СОЁЛЫН  
ӨВ САН

**БУДДИЗМ ДЭХ ХҮН ТӨРӨЛХТӨНИЙ  
ТАНИН МЭДЭХҮЙН ҮЙЛ ЯВЦ  
ДЭЛХИЙ НИЙТИЙН ТҮҮХЭН  
ХӨГЖЛИЙН ҮЙЛ ЯВЦ БОЛОХ НЬ**

**О. Чимэг**

(Зонхавын «Бодь мөрийн зэрэг» зохиолоор)

**«Өөрийн сэтгэлийг шинжилвээс бүхэн ном  
өөрийн сэтгэл дор оршиму»**

(Зонхава. Бага бодь мөрийн зэрэг оршив).

Зонхавын «Бодь мөрийн зэрэг» зохиолыг оюун судлалын ном гэдэг билээ. Үүнтэй холбогдуулан өгүүлэн буй судрын үзэл санаанд тулгуурлан буддизмд бодид хүрэх мөр буюу оюун судлал нь хүн төрөлхтөний танин мэдэхүйн үйл явц бөгөөд түүнийг дэлхий нийтийн түүхэн хөгжлийн үйл явц болгожээ хэмээн үзэж байна.

Ертөнцийг үзэх нэгэн үзэл болсон шашны сургаал орчлонгийн зовлон хамаг бүхнийг нисванис төрүүлдэг бөгөөд түүний ёзоор минээрхэн барих буюу би-д үзэх мунхаг үзэл, түүнээс би үгүйг оносон үнэний мэдлийг олж бурхан (гэгээрсэн) болохыг шашны эцсийн зорилго болгодог байна.<sup>1</sup>

Их хөлгөний уламжлал ёсоор нийт хүмүүсийг доод, дунд, дээд төрөлхтөн гэж хуваан нисванисыг алга болгож, энэ ертөнцөөс тонилж бурхан болох зорилго тавьсан хүнийг дунд буюу дээд төрөлхтөн гэх бөгөөд тэд үнэнийг танин мэдэх таван мөрөөр явдаг. Тэднийг авьяас чадварын төрөл, оюун бэлигийн хэмжээ, санааны нь хувьд бас нарийвчлан ангилдаг.<sup>2</sup>

Энэ уламжлалын дагуу Зонхава нянтай, (шравка), ранжалыг (пратьекабудда) дунд төрөлхтөн, бодьсатваг их төрөлхтөнд оруулсан бөгөөд гэхдээ тэр үзэхдээ их, бага хөлгөний аль алины арга буюу эдгээр гурван язгуурын хүн өөр өөрийнхөө замаар явж бурхан болж болохыг зөвшөөрсөн байна. Энэ тухай «Бодь мөрийн зэрэгт», «Нагаржуна бэр чу бурхан пратьекабудда нугууд хийгээд ширваанг нугууд бэр магад шүтсэн тонилохын гагцхүү мөр ину цөмөөс бус үгүй...»<sup>3</sup> гэсэн байдаг. Ямар ч аргаар тонилж болно. Гэхдээ эцсийн гол зорилгыг бодь сэтгэл үүсгэх гэж үзэж «...хоосон чанарыг оносон бэлигээр их, бага хөлгөн болон ялгагдах бус, бодь сэтгэл хийгээд ихэнх явдал нугуудаар ялгах мөн буюу»<sup>4</sup> гэсэн байдаг.

Бодь сэтгэл үүсгэнэ гэдэг нь амьтны тус дор бурхныг олохуй хүслийг үүсгэх»<sup>5</sup> явдал бөгөөд их төрөлхтөнд зориулсан сургаал номлолд гардаг. Чухамхүү бодь сэтгэлээр, бусдын тусын тулд зүтгэснээр их хөлгөний зам бага хөлгөнийхөөс ялгардаг байна. «Тиймийн тул бодь сэтгэлийг увьдасны гол болгон барьж судлах хэрэгтэй»<sup>6</sup> гэж үзжээ.

Иймд нянтай, ранжалын буюу бага хөлгөний аргыг дунд төрөлхтөний мөрд оруулж, мөр бүхний эцсийн зорилго бол бодь сэтгэлийг үүсгэх явдал гэж үзэж бүхэлд нь авч үзвэл гурван хөлгөн нь нэг л зам мөрийн үе гишүүн буюу арга юм.<sup>7</sup>

Бурхан болох үйл явцын эцсийн зорилго нь илт мэдэл, «бэлгэ үгүйн зөн»<sup>8</sup> бөгөөд түүний тодорхойлолтуудыг аваад үзэхэд үнэмлэхүй үнэнийг олох»<sup>9</sup>, «ямагт чанарыг онох»<sup>10</sup>, «тэрхүү чанарыг илт болгох»<sup>11</sup>, «бүхэн бүгдийг илт тодорхойя үзэхүй»<sup>12</sup> зэрэг болно.

Өөрөөр хэлбэл бэлгэ үгүйн зөнд хүрэх буюу бурхан болох гэдэг нь бүхнийг танин мэднэ, танин мэдэхүйн туйлд хүрнэ гэсэн үг юм.

Энэ үйл явцын онцлогийг «тэнцэл үгүй зөн дор ану бэлиг барамидын увьдаснаас өөрийн сэтгэлийг шинжилвээс бүхэн ном өөрийн сэтгэл дор оршиму»<sup>13</sup> гэсэн үгээр илэрхийлж болох юм.

Танин мэдэхүйн энэ үйл явцыг өөрийн сэтгэлийг танин мэдэх үйл явц гэж үзсэн нь гадаад ертөнцийг танин мэдэхээс буцна гэсэн хэрэг биш, харин хүний оюун хязгааргүй болохыг илэрхийлсэн юм. «Дээд утга үнэний бэлгэ чанар ану орохуйгаас: мэдэгдэхүүн үнэхээрийн утгыг үзсэнээр олсон дор номлосон... түүний тайлбараас: түүн дор дээд утга ану үнэхээр айлдагч нугуудын ялгамжаат бэлгэ бэлигийн оюун өөрөө бэр өөрийн мөн чанарыг олсон мөн буюу»<sup>14</sup> Боломжийн хувьд хүний оюун сэтгэхүй бүхнийг агуулж чадна. Хүний оюун сэтгэхүйн хязгааргүй энэ боломжийн тухай «оюун хий бэр орших хязгаалал үгүй буйн тул болой»<sup>15</sup> гэсэн байдаг.

Ертөнцийн аливаа юмс үзэгдэл бидний өөрсдийн амьдрал ахуйтай холбоо бүхий, бидний ухамсраар дамжин танин мэдэхүйн оногдохуун болдог тул тэдгээр юмс үзэгдлийг зөвхөн хүний оюун ухамсарт хамаатуулан авч үзсэн байна. Хэрэв марксист философид философийн үндсэн асуудал болгон ахуй, ухамсрын харьцааг авч үзэж, ахуй нь ухамсраас үл хамааран оршино гэсэн утгаар түүнийг ухамсартай харьцуулахад анхдагч юм гэж үздэг бол буддын философид өгүүлэн буй судраас үзэхэд философийн энэ асуудлыг үздэггүй, нэгэнт бүх юмс хүний ухамсраар л танин мэдэгдэх төдийгүй бидний амьдралын аливаа асуудал оюун ухамсарт мэдрэгдэж байж зовлон жаргал болдог тул танин мэдэхүйн үйл явцыг оюун судлал буюу өөрийн сэтгэлийг шинжлэх үйл явц болгожээ.

Танин мэдэхүйн үйл явц хүний танин мэдэхүйн үйл явц байдаг. Байгаль, нийгэм, орчлон ертөнц, аливаа юмс үзэгдэл чухамхүү хүний оюун ухамсраар дамжин танин мэдэхүйн оногдохуун болдог. Иймд хүний танин мэдэхүй нь өөрөө өөрийгөө, өөрийн сэтгэлийг болон өөрийн оюун сэтгэлээр дамжуулан байгаль, нийгэм, ертөнцийг танин мэдэх үйл явц амой.

Ингэхлээр хүн нь байгалийн нэгэн амьд организм болох бөгөөд хязгааргүй оюун ухамсартай тул тэр оюун сэтгэлээр дамжин дэлхий ертөнц өөрөө өөрийгөө танин мэднэ гэсэн хэрэг.ө

Нөгөө талаар хүний оюун боломжийн хувьд хязгааргүй боловч хязгааргүй энэ ухамсар мөнх бус, хязгаартай биетэй холбоотой байдаг тул танин мэдэхүйн бололцоогоо бүрэн илэрхийлээгүй болохын хувьд хязгаарлагдмал. Энэ утгаар тодорхой бие хүний ухамсар сэтгэхүй мөнх бусын учир бас л нэгэн амьдралаар хязгаарлагдах мэт би үгүй. Гэхдээ хүн төрөлхтөний ухамсар бол хязгааргүй. Учир нь би үгүйн тухай ойлголт нь байгаль, нийгмийн хөгжил харилцан шүтэлцээ бүхий үргэлжилсэн үйл явц болохыг илэрхийлсэн ойлголт бөгөөд хүний танин мэдэхүйн үйл явцтай түүнийг холбож үзэхэд бие хүний ухамсар хийгээд нийт хүн төрөлхтөний ухамсар нэгэн үндэст үргэлжлэл болохыг илэрхийлсэн бөгөөд үйлийн үрийн тухай ойлголт нь энэ харилцан холбоог хүний ёс суртахууны үйл ажиллагаанд холбогдуулан илэрхийлдэг юм.<sup>16</sup>

Энэ үүднээс бие хүний ухамсрыг хязгаартай гэж үзэж болох боловч нийт хүн төрөлхтөний хязгааргүй оюун сэтгэлтэй нэгэн үндэст үргэлжлэл болох тул хязгааргүй.

Иймд олон төрлийг дамжин олдог үнэмлэхүй үнэн буюу гаслангаас нөгцөх явдал нь тодорхой бие хүний танин мэдэхүйн хөгжил байхын зэрэгцээ нийт хүн төрөлхтөний танин мэдэхүйн хязгааргүй хөгжил юм. Тухайн бодгаль танин мэдэхүйн хязгааргүй боломжоо илэр-

хийлж буддын ёсоор «бурхан болсон» боловч хүн төрөлхтөний танин мэдэхүйн энэ үйл явц хязгааргүй болох нь амьтан тоолошгүй олон, тэднийг гэтэлгэж, бурхан болгох үйл явц хязгааргүй болох тухай хэлснээс тодорхой. Энэ тухай: «заримууд хүмүүс энэ ертөнц дор үхэж бус ертөнц дор өгүүтгээд одох үгүй боловч үйл үйлдсэн нугууд хэзээ чу үл хомсдому. Орчлон дор чу цагаан, хар үйлс боловсорму...»<sup>17</sup> гэсэн байдаг.

Ингэхлээр бурхан болно гэдэг буддын сургаалын туйлын зорилго нь бие хүний танин мэдэхүй хязгааргүй туйл руугаа хөгжих, нөгөө талаар нийт хүн төрөлхтөний бурхан болох үйл явц гэж үзсэн нь хүн төрөлхтөний танин мэдэхүй хязгааргүй туйл руугаа хөгжих түүхэн үйл явц амой. Өөрөөр хэлбэл бурхан болно гэдэг нь уг мөн чанартаа ямар нэгэн далдын ид шидийг огтхон агуулаагүй, харин хүн төрөлхтөний өөрөө өөрийгөө танин мэдэх түүхэн үйл явц болно. Өөрөөр хэлбэл энэ нь бие хүн өөрийгөө хийгээд нийгэм, хүн төрөлхтөний оюун сэтгэхүй өөрийгөө танин мэдэх үйл явц юм. Тэхлээр энэ нь нэг талаар нийгэм судлал, нөгөө талаар байгаль дэлхийн судлал юм. Учир нь бид өөрийгөө танин мэднэ гэдэг нь амьдарч буй нийгмээ төдийгүй үүгээр дамжин байгаль, дэлхийгээ танин мэднэ гэсэн хэрэг. Энэ утгаар өөрийн сэтгэлийг шинжилнэ гэдэг нь бүхнийг шинжилнэ гэсэн үг.

Ингэхлээр бурхан болно гэдэг нь бие хүн хийгээд нийт хүн төрөлхтөн байгалийн нэгэн амьд организм болохын зэрэгцээ хязгааргүй боломжийг агуулах оюун сэтгэхүйтэй болох тул тэр оюун ухамсраар дамжин дэлхий ертөнц өөрөө өөрийгөө танин мэдэх үйл явц мөн.

Ингэхлээр Зонхавын үзэл санаагаар буддизмд бие хүн хийгээд хүн төрөлхтөний оюун сэтгэхүйн хөгжлийг дэлхий нийтийн түүхэн хөгжлийн үйл явц, хүн төрөлхтөн дэлхий нийтийг танин мэдэх субъект болохын хувьд түүний хөгжлийг дэлхий нийтийн түүхэн хөгжлийн үйл явц болон тусгажээ.

Гурван төрөлхтөний эцсийн зорилго нь бодь сэтгэлийг үүсгэх явдал гэдэг нь бодь сэтгэлтэй хүн нь бид бүхэн нэгэн үндэст үргэлжлэл тул ганц өөрөө гэтлээд эцсийн амгалан жаргалан олохгүй бөгөөд орчлонгийн хамаг амьтан, бүх юмс үзэгдлийн хувь заяа харилцан уялдаатай, нэг нэгнээс харилцан хамаарах тул эцсийн амгалан олно гэдэг нь нийт бусдын амгалангаас хамаарна гэдгийг ойлгох болно.

1. О. Чимэг Шашны номлол дахь сэтгэл зүйн зарим асуудал. — Философи, эрхийн судлал. № 13
2. E. Obermiller, The doctrine of Prajna--paramita as exposed in the Abhisamayalan kara of Maitreyi Leningrad 1934 14-16 дахь тал
3. Лувсандагва. Бага бодь мөрийн зэрэг оршив. Гар бичмэл, 98 а
4. Мөн тэнд, 98 а
5. Мөн тэнд 101 б
6. Мөн тэнд 98 б
7. О. Чимэг., Шашны номлол дахь сэтгэл зүйн зарим асуудал. Философи эрхийн судлал, № 13
8. Лувсандагва, Бага бодь мөрийн зэрэг оршив. Гар бичмэл, 242 а
9. Мөн тэнд 226 б
10. Мөн тэнд 242 б.
11. Мөн тэнд 229 а
12. Мөн тэнд 230 б
13. Мөн тэнд 237 б.
14. Мөн Тэнд 223 б
15. Мөн Тэнд, 199 а
16. О. Чимэг, Бодь мөрийн зэрэг дэх үйл үрийн тухай номлол, ШУА-ийн мэдээ, 1991, № 2
17. Лувсандагва Бага бодь мөрийн зэрэг оршив. Гар бичмэл, 209 а